

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/313/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АЛБАН БУС НАСАН ТУРШИЙН
БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjarqalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024-02-25 № 9/149
танай _____-ны № _____-т

「ТӨВ АЙМГИЙН АЛБАН БУС НАСАН
ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН
ДАРГА Т.ИДЭР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 2 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 98,0 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,763,801.90	72,324,900.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	48,215,824.90	67,949,000.88
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	48,215,824.90	67,949,000.88
31210	Төгрөг	48,215,824.90	67,949,000.88
31211	Төрийн сангийн харилцах	48,215,824.90	67,949,000.88
33	АВЛАГА	0.00	541,852.23
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	541,852.23
35	БАРАА МАТЕРИАЛ	2,547,977.00	3,834,047.00
35400	Хангамжийн материал	2,547,977.00	3,834,047.00
35410	Бичиг хэргийн материал	654,780.00	598,750.00
35420	Аж ахуйн материал	1,873,197.00	3,215,297.00
35470	Бусад хангамжийн материал	20,000.00	20,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,002,082.31	43,466,361.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,002,082.31	43,466,361.71
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	19,148,360.23	42,825,306.39
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	17,064,770.00	38,124,770.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,185,986.58	-8,673,940.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,202,000.00	16,474,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,014,349.19	-3,181,449.27
39217	Ном	81,926.00	81,926.00
39300	Биет бус хөрөнгө	853,722.08	641,055.32
39301	Програм хангамж	1,100,000.00	1,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-246,277.92	-458,944.68
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	70,765,884.21	115,791,261.82
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	70,765,884.21	115,791,261.82
51	Засгийн газрын хувь оролцоо	70,765,884.21	115,791,261.82
51100	Засгийн газрын оруулсан капитал	81,926.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	81,926.00	0.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	81,926.00
51200	Хуримтлагдсан үр дүн	70,683,958.21	115,709,335.82
51210	Өмнөх үеийн үр дүн	-81,926.00	70,683,958.21
51220	Тайлант үеийн үр дүн	70,765,884.21	45,025,377.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	70,765,884.21	115,791,261.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	168,710,399.99	134,449,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,074,399.99	25,422,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	55,074,399.99	25,422,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	54,061,402.99	25,422,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,012,997.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	113,636,000.00	109,027,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	113,636,000.00	109,027,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	113,636,000.00	109,027,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	76,344,515.78	89,424,422.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76,344,515.78	89,424,422.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,344,515.78	89,424,422.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,950,513.38	69,820,001.54
210101	Үндсэн цалин	39,462,658.19	43,338,090.18
210102	Нэмэгдэл	4,756,670.59	23,442,311.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,360,000.00	1,360,000.00
210104	Урамшуулал	6,371,184.60	1,679,599.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,405,571.72	9,937,590.25
210201	Тэтгэврийн даатгал	4,418,494.16	6,706,202.30
210202	Тэтгэмжийн даатгал	519,822.87	1,141,372.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	415,858.25	814,096.29
210204	Ажилгүйдлийн даатгал	77,871.05	115,992.59
210205	Эрүүл мэндийн даатгал	973,525.39	1,159,926.67
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	400,000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,988,430.68	9,266,830.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,994,260.00	3,887,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,134,850.00	512,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,859,320.68	4,867,720.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	92,365,884.21	45,025,377.61
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,600,000.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	21,600,000.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	70,765,884.21	45,025,377.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	113,636,000.00	109,027,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	113,636,000.00	109,027,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	113,636,000.00	109,027,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	113,636,000.00	109,027,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,020,175.10	86,384,624.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,020,175.10	86,384,624.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,020,175.10	86,384,624.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,950,513.38	70,361,889.72
210101	Үндсэн цалин	39,462,658.19	43,338,090.18
210102	Нэмэгдэл	4,756,670.59	23,984,199.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,360,000.00	1,360,000.00
210104	Урамшуулал	6,371,184.60	1,679,599.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,405,571.72	9,937,554.30
210201	Тэтгэврийн даатгал	4,418,494.16	6,706,202.35
210202	Тэтгэмжийн даатгал	519,822.87	1,141,336.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	415,858.25	814,096.29
210204	Ажилгүйдлийн даатгал	77,871.05	115,992.59
210205	Эрүүл мэндийн даатгал	973,525.39	1,159,926.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,664,090.00	6,085,180.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,992,490.00	4,999,880.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,671,600.00	1,085,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	49,615,824.90	22,643,175.98
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,400,000.00	2,910,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,400,000.00	2,910,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,400,000.00	2,910,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,400,000.00	2,910,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,400,000.00	-2,910,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	48,215,824.90	19,733,175.98
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	48,215,824.90
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,215,824.90	67,949,000.88

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	81,926.00	-81,926.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	81,926.00	-81,926.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	70,765,884.21	70,765,884.21
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	81,926.00	70,683,958.21	70,765,884.21
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	81,926.00	70,683,958.21	70,765,884.21
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	81,926.00	70,683,958.21	70,765,884.21
19	Тайлант үеийн үр дүн	0.00	45,025,377.61	45,025,377.61
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	81,926.00	115,709,335.82	115,791,261.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	115,716,400.00	89,294,624.02	89,294,624.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,716,400.00	89,294,624.02	89,294,624.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,716,400.00	89,294,624.02	89,294,624.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,859,700.00	70,361,889.72	70,361,889.72
210101	Үндсэн цалин	68,333,700.00	43,338,090.18	43,338,090.18
210102	Нэмэгдэл	25,567,200.00	23,984,199.90	23,984,199.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	1,360,000.00	1,360,000.00
210104	Урамшуулал	958,800.00	1,679,599.64	1,679,599.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,856,700.00	9,937,554.30	9,937,554.30
210201	Тэтгэврийн даатгал	8,063,000.00	6,706,202.35	6,706,202.35
210202	Тэтгэмжийн даатгал	948,500.00	1,141,336.40	1,141,336.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	758,700.00	814,096.29	814,096.29
210204	Ажилгүйдлийн даатгал	189,400.00	115,992.59	115,992.59
210205	Эрүүл мэндийн даатгал	1,897,100.00	1,159,926.67	1,159,926.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.00	8,995,180.00	8,995,180.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,999,880.00	4,999,880.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	3,995,300.00	3,995,300.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	115,716,400.00	109,027,800.00	109,027,800.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	109,027,800.00	109,027,800.00	109,027,800.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	109,027,800.00	109,027,800.00	109,027,800.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАНААС	6,688,600.00	0.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,688,600.00	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	48,215,824.90	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	67,949,000.88	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсрол төвийн үйл ажиллагааны зорилго нь иргэн бүрд насан туршийн боловсролыг эзэмших тэгш боломж бүрдүүлж сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсрол төв нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 онд 1 зорилт 2 арга хэмжээтэй баталснаас нийт 94,2 хувьтай дүгнэгдсэн байна. Тус байгууллага нь 6 орон тоотой боловч 2023 онд 1 захирал, 1 нягтлан бодогч, хүний нөөц сургалтын менежер 1 нийт 3 орон тоогоор ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 оны 11 сард Төв аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтад хамрагдаж 68,0 хувьтай үнэлэгдсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,025.4 мянган төгрөгөөр буюу 63,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	48,215.8	67,949.0	19,733.2
Авлага		541.8	541.8
Урьдчилж гарсан зардал, тооцоо			
Бараа материал	2,548.0	3,834.0	1,286.0
Үндсэн хөрөнгө	20,002.1	43,466.4	23,464.3
Нийт хөрөнгө	70,765.9	115,791.3	45,025.4
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	70,765.9	115,791.3	45,025.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	70,765.9	115,791.3	45,025.4

2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 67,949.0 мянган төгрөг болж өмнөх оноос 19,733.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн цалин, нэмэгдэл зэргийн зардал хэмнэлт гарснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 3,834.0 мянган төгрөг, 1,286.0 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн хөрөнгөөр 4,156.9 мянган төгрөгөөр бичиг хэрэг, хангамжийн бараа материал худалдан авсан, мөн байгууллагын үйл ажиллагаанд 2,870.8 мянган төгрөгийн аж ахуйн бараа материал болон бичиг хэргийн зардлыг гаргаснаас шалтгаалсан байна.

Акталсан болон өөр газарт шилжүүлсэн зэрэг хангамжийн бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө данс 23,464.3 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн хөрөнгөөр 2,910.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж авсан, мөн Төв аймгийн 100 жилийн ойгоор хандиваар Нар-хан ХХК, Тэвхэн ХК-уудаас 25,422.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг авсан. Үүнд: /4 ш оёдлын машин, ширээ сандлууд/

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 109,027.8 мянган төгрөг, нийт зарлагыг 109,027.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 109,027.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 109,027.8 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 109,027.8 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 89,294.6 мянган төгрөг буюу 77,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 25,703.7 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалин, нэмэгдэл болон цалин хөлстэй холбоотой зардлыг 24,004.3 мянган төгрөгөөр, бусад хангамжийн бараа материал зардлыг 1,699.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Данс код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71806	Албан бус насан туршийн боловсрол үйл ажиллагаа	109,027.8	89,294.6	19,733.2	77,6
81834	Боловсролын арга хэмжээ	94,366.2	70,361.9	24,004.3	74,6
81835	Сургалтын арга хэмжээ	10,000.0	9,000.0	1,000.0	90,0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төв нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан

1	Албан бус насан туршийн боловсрол	2023-12-31	100	100	109,027.8	89,294.6
2	Боловсролын арга хэмжээ	2023-12-31	100	100	94,366.2	70,361.9
3	Сургалтын арга хэмжээ	2023-12-31	100	100	10,000.0	9,000.0

Хэрэгжилт дутуу арга хэмжээнүүд байхгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Албан бус боловсролын насан туршийн төв нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 9,000.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, бичиг хэрэг хангамжийн бараа материалыг шууд худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 2,910.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,156.9 мянган төгрөгийн бичиг хэрэг, хангамжийн бараа материалын худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийгдсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Албан бус насан туршийн боловсролын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог, нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн

Албан бус насан туршийн боловсролын төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 65,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 1,300.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1,040.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллан, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Албан бус насан туршийн боловсролын төв нь 2023 онд 6 орон тоотой ажиллахаас 3 орон тоотой ажиллаж багшийн орон тоог хэмнэсэн болон нярав нь бичиг хэргийн ажилтны үүргийг давхар хариуцан ажилласнаар нийт цалингийн төсвийг 25,102,3 мянган төгрөгөөр хэмнэсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалттай гэж үзсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 156 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 155 мэдээллийг байршуулж, 1 мэдээллийн оруулах хугацаа нь болоогүй. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 2023 оны 9 дүгээр сарын 30-ны харилцах дансны 1,096.8 мянган төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй гэсэн 1 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийг шалгалтын хугацаанд хэрэгжүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 100 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1		1		100
Нийт дүн	1		1		100

Урд оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,096.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,096.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 541.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

1. Анхан шатны бүртгэлтэй холбоотой асуудал

Залруулсан алдаа:

Аудитаар анхан шатны бүртгэл болон нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол, тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж баталгаажуулав. Үүнд: Албан бус насан туршийн боловсролын үндэсний төвийн 2023 оны 9 сарын 30-ны өдрийн дансны 1,096.8 мянган төгрөгийн үлдэгдлийн баталгааг хийлгэж 2023 оны 3 дугаар улирлын төсвийн тайланд хавсаргав.

5.3 Зөвлөмж

1. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2023 оны жилийн эцсээр нийгмийн даатгалын хэлтэст 541.8 мянган төгрөгийг тооцоолол судалгаагүй илүү шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т “Дансны өглөг, авлага ба өр төлбөрийн тооцоог хянах ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтыг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж

Холбогдох хууль тогтоомжийн дагуу өр авлага үүсгэхгүй ажиллах, зөрчлийг дахин гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023 оны 9 дүгээр сарын 30-ны дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй	1	1,096.8					1	1,096.8				
Дүн	1	1,096.8					1	1,096.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага, өр төлбөрийг барагдуулаагүй /НДШ-ийн тайлангаар гарсан/	1	541.8					1	541.8				
Дүн	1	541.8					1	541.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn